## ХАРИЛЦАА ХОЛБООНЫЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугээр сарын 18 өдөр Улаанбаатар хот

| № | Зорилго | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгө | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн үр дүн, хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 1.1.Хорооны ХАСХОМ гаргах албан тушаалтны 2024 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах, холбогдох мэдээ тайланг, АТГ-т хүргүүлэх арга хэмжээг авах | 2 дугаар сарын 28 | - | -Албан хаагчдын 2024 оны ХАСХОМ-ийг гаргуулж, мэдээ, тайланг нэгтгэн АТГ-т хүргүүлсэн байх | ХХЗХ-ны нийтийн албан тушаалтны 2024 оны ХАСХОМ-ийг албан хаагчдаар гаргуулан, ХАСХОМ-1, ХАСХОМ хураангуй, ХАС-ын хураангуй тайланг ХХЗХ-ны 2025.02.25-ны өдрийн 01/364 тоот албан бичгээр болон АТГ-ын хариуцсан ажилтны албан мэйлээр цахимаар илгээсэн. Тус Хорооны ЭБАТ-аас ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдвээр сургалтыг 2025.01.06-ны өдөр Хорооны нийтийн албан тушаалтнуудад зохион байгуулсан. Гүйцэтгэлийн хувь- 100% |
| | | 1.2 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг АТГ-аар хянуулах, хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | Тухай бүр | - | -Нийтийн албанд томилогдох иргэний ХАСУМ-ийг АТГ-аар хянуулсан байх -Дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон байх | ХХЗХ-ны нийтийн албан тушаалд тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар тухай бүр хянуулж, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж байна. 2025 онд Хорооны ажлын албанд мэргэжилтэн буюу түүнээс дээш ангиллын албан тушаалд шинээр томилогдох, шилжин томилогдсон албан хаагч, иргэний жагсаалт, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх | мэдээллийг Хорооны CRC.GOV.MN цахим хуудас болон “Шудрага ёс-хөгжил дэвшилд” мэдээллийн самбарт байршуулсан. 2025 оны тус хорооны удирдах албан тушаалд шилжин томилогдсон 7 албан хаагчийн ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж хянуулан, албан тушаалд томилогдсон.<br>Гүйцэтгэл – 100% |
| | | 1.3.Албан тушаалд томилсон хүний нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | Тухай бүр | - | -Ажилд томилсон тушаал, шийдвэрийн жагсаалтыг ил тод, нээлттэй мэдээлсэн байх | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Хорооны хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд 2025 онд ХХЗХ-ны Ажлын албанд шинээр болон шилжин ажилд томилогдсон ажилтны жагсаалт, мэдээллийг CRC.GOV.MN цахим хуудсанд тогтмол шинэчлэн байршуулж байна.<br>https://www.crc.gov.mn/azhiltan-alban-haagchdyn-shilzhilt-h-d-lg-nij-talaarh-medeelel,<br>Гүйцэтгэл 100% |
| | | 1.4.Хууль, журамд заасан үндэслэлээр албан хаагчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг гаргуулж ажиллах | Тухай бүр | - | -Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг хуульд заасан үндэслэлээр гаргуулж, мэдүүлэг бүрдүүлэлтийн системд бүртгэх, холбогдох арга хэмжээг авч | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчил үүссэн гэж ойлгогдохуйц нөхцөл үүссэн тохиодолд мэдэгдлийг хэрхэн гаргах талаар албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.<br>Гүйцэтгэл – үнэлэх боломжгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан байх | |
| 2. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 2.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, зурагт хуудас, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбар зэрэгт байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн байх | Тухай бүр | - | -Үр дүнг тооцож тайлагнасан байх /түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо/<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх | АТГ-аас бэлгэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий сурталчилгааны материалуудыг Хорооны цахим хуудас болон “Шудрага ёс-хөгжил дэвшилд” мэдээллийн самбарт байршуулж олон нийт болон албан хаагчдад сурталчилж байна. АТГ-аас зарласан “Авлигын эсрэг нэгдье” уриалгыг дэмжиж мэдээллийг олон нийтэд түгээсэн. Авилгыг мэдээлэх утас -110 Авилга гэж юу вэ? Авлигын хэлбэрүүд, Авлига – Авлигын хор уршиг зэрэг сурталчилгааны материалуудыг байршуулж, олон нийтийн сүлжээгээр түгээсэн.<br>Гүйцэтгэл – 80% |
| | | 2.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах | 1-4 дугаар улирал | - | 2-оос доошгүй сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх | Хорооны үйл ажиллагааг сурталчлах, холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл эзэмших нөхцөл, шаардлага, журам, стандартыг танилцуулах, салбарын статистик тайлан мэдээг харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон олон нийтэд сурталчлах зорилгоор хагас жил тутамд гаргадаг ***“Харилцаа холбооны зохицуулах хороо”*** сэтгүүлийн 2025 оны 2 удаагийн дугаарт тус Хорооны захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, ХХЗХ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, авлигын талаарх ойлголт, авлигын хор |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөнөөл шалтгаан, авлигын эсрэг олон улсын өдрийн талаарх мэдээлэл, салбарын шинээр болон шинэчлэн баталсан хууль тогтоомж, тус хорооноос гаргасан "Авлигын эсрэг залуучууд – Шудрага нийгмийн төлөө" постер зэргийг нийтэлж авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон олон нийтэд сурталчилсан.<br>Гүйцэтгэл-100% |
| | | 2.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шудрага ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах | 1-4 дүгээр улирал | - | -Мэдээллийг сар бүр шинэчлэх | Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомжийг мэдээлэн сурталчлах "Шудрага ёс- хөгжил дэвшилд" самбарыг ХХЗХ-ны ажлын байранд байршуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мэдээллийн самбарт 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025 онд ХАСУМ хянуулж, ажилд томилогдсон албан хаагчийн жагсаалт, АТГ-аас гаргасан сурталчилгааны материал, ХХЗХ-ноос гаргасан" Авлигад үгүй гэж хэлье", "Авигын эмрэг нэгдье", "Бид авлигаас ангид байгууллага" зэрэг постерыг тус тус байршуулж сурталчилсан.<br>Гүйцэтгэл – 100% |
| | | 2.4.Хорооны үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, | 1-4 дүгээр улирал | - | -2-оос доошгүй сурталчилгаан ы материал боловсруулсан байх<br>-Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан | Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах болон сунгах хүсэлтийг хэрхэн цахим хэлбэрээр гаргах, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал, зөвшөөрлийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэдэг талаарх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээр сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх | | | ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх<br>-Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх | богино хэмжээний 6 төрлийн видео шторкыг хийж, Хорооны цахим хуудас, пэйж хуудсуудаар зөвшөөрөл эзэмшигчид болон олон нийтэд түгээсэн.<br><br>Гүйцэтгэл – 100% |
| 3. | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах | 3.1. Албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | 2-4-р улирал | 2.0 | Нийт албан хаагчид болон шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн танхимын болон цахим сургалтад хамруулсан байх | Тус Хорооны ЭБАТ нь 2025 оны 3 дугаар сарын 27-ноос 28-ны өдрүүдэд АТГ-аас зохион байгуулсан “Авлигын эсрэг сургагч багш бэлтгэх” сургалт болон АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтуудад хамрагдсан. Хороонд шинээр томилогдсон албан хаагчдад шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх болон ажилтны ёс зүйн дүрмийн талаар 4 удаагийн сургалт хийж, мэдээлэл өгч ажиллав.<br>Гүйцэтгэл- 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | 3-4-р улирал | - | -Дотоод нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх | Хорооны орон нутаг дахь төлөөлөгч нар 2025 онд шинээр томилогдсон бөгөөд 2026 онд сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br><br>Гүйцэтгэл – үнэлэх боломжгүй |
| 4. | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 4.1.Бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах | 1-4-р улирал | - | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх | Хорооноос бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулж байгаа бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын талаар мэдсэн тохиодолд авлигын талаар 110 утсанд мэдэгдэх үүрэг бүхий заалтыг тогтмол тусгаж, гэрээг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>Гүйцэтгэл – 100% |
| | | 4.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон | 1-4-р улирал | - | -Олон нийтийн хяналтад хамруулах | "Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | | | чиглэлийг тодорхойлсон байх<br>-Сургалт, мэдээлэл авсан байх<br>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан, зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлсэн байх | журам"-ын хүрээнд 2.1 дэх хэсэгт заасан холбогдох мэдээллийг shilen.gov.mn цахим хуудаст тогтмол мэдээлж, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээнд тогтмол хамрагдаж байна. Хорооны үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, бүтцийн зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүүгийн болон бусад мэдээллийн нээлттэй, ил тод байдлын хүрээнд үнэлгээ хийгдэж байна.<br>Гүйцэтгэл -70% |
| 5. | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, өөрчлөлт оруулах, зэрэг үйл ажиллагааг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах | 1-4-р улирал | - | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх | Авлигын эрсдэл, авлигыг бууруулах арга хэмжээний хүрээнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар гаргах нөхцлийг бүрдүүлж, customer.gov.mn цахим хуудсаар дамжуулан зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн.<br>2025 онд зөвшөөрөл сунгуулах хүсэлтийн 65 хувийг цахим хэлбэрээр хүлээн авч, хүсэлтийг шийдвэрлэж ажилласан.<br><br>Мөн зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбаршуулах, шуурхай болгох хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 тоот дүгнэлтийн 1.2-т заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцаа зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасаж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор холбогдох мэдээллийг ирүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд даалгасан.<br>Хууль зүй, дотоод хэргийн яам Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж тус хорооны 10 захиргааны хэм хэмжээний актад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа байна хэмээн дүгнэж, холбогдох арга хэмжээ авч хүчингүй болгох тухай албан бичгийг ирүүлсэн бөгөөд тус хорооны зүгээс баталсан бүх баримт бичгүүддээ үзлэг хийж 6 захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь, 8 захиргааны хэм хэмжээний актын 82 заалтыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.<br>Гүйцэтгэл – 90% |
| | | 5.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох хүнд суртлыг бууруулах чиглэлээр сургалт, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх | 2-4-р улирал | - | -2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байх<br>-хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион | Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зориулсан /тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг цахимаар гаргах болон статстистик тайлан мэдээг гаргах, програмын шинэчлэлтийг танилцуулах/ 2025 оны 2, 9, 11, 12 дугаар сард зохион байгуулсан 5 удаагийн сургалтад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан байх | тус Хорооны ЭБАТ-аас зохион байгуулж, сургалтад 120 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч тэдгээрийн төлөөлөл оролцсон. Гүйцэтгэл- 80% |
| 6. | Хорооны удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл санаачлага өрнүүлэх | 6.1.ЗУХАГ-аас 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийн явцыг 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор, хэрэгжилт, хүрсэн үр дүнг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийт албан хаагчдад танилцуулах | 1-4-р улирал | - | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх<br>-Албан хаагчдаас авлигын эсрэг үйл ажиллагааны талаар гаргасан санал, санаачлагыг хэлэлцсэн байх | ХХЗХ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөлөгөөг боловсруулж, Хорооны даргаар батлуулсан. Төлөвлөгөөг нийт албан хаагчдад хүргүүлж, Хорооны цахим хуудас болон “Шудрага ёс-хөгжил дэвшилд” самбарт байршуулсан.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган нийт албан хаагчдад мэдээлэв.<br>Гүйцэтгэл -100% |
| | | 6.2.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага уриа, аянд нэгдэх | Тухай бүр | - | Авлигын эсрэг санал, санаачлага, аянд нэгдсэн байх | АТГ-аас гаргасан Авлигын эсрэг аянд нэгдэж, нийт албан хаагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн сургалтуудад сурталчилсан.<br><br>https://www.facebook.com/crcmongol<br>Гүйцэтгэл -80% |
| 7. | Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | 7.1.Авлигын эсрэг хууль болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудаст байршуулж, | 1-4-р улирал | - | Хуулийг хэрэгжүүлж, иргэд олон нийтийг мэдээллээр хангасан байх | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасны дагуу Хорооны үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцтэй холбоотой мэдээллийг Хорооны crc.gov.mn, shilendans.mn цахим хуудсанд байршуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж байна.<br>https://www.crc.gov.mn/home |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | иргэд, олон нийт танилцах боломжоор хангах | | | | https://shilendans.gov.mn/organization/4986?ry=2025&group=5<br>Гүйцэтгэл – 100% |

Танилцсан:

Харилцаа холбооны

зохицуулах хорооны дарга Б.Чинзориг

Хянасан:

ЗУХАГ-ын дарга З.Эрдэнэчулуун

Боловсруулсан:

ХХ-ийн дарга Б.Нямдулам